

Зар мэдээний загвар

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт** компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18, компанийн МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдуулахаар шийдвэрлэсэн билээ.

Энэ цаг үед дэлхийн хэмжээнд COVID-19 шинэ коронавирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Монгол улсын Засгийн газраас шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорионы онцгой дэглэмийг тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ныг дуустал сунгаж, онцгой нөхцөл байдал үүссэн тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийг 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байрны 308 тоот өрөөнд ирж ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөх боломжтой бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах чиглэлээр ажиллах болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр онлайн орчинд зайны технологийг ашиглан зохион байгуулахтай холбогдуулан шаардлагатай мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсаар мэдээлэх бөгөөд хурал зохион байгуулахтай холбоотой асуудлаар хурал зохион байгуулах комисс болон компанийн 976-11-325051, info@takhico.mn хандаж болно.

ТАХЬКО (ХК) КОМПАНИ

